

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/114/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Эл Би Альфа Экспэйншин аудит ХХК-ны

Аудитор: Г. Баясгалан

Утас: 95438030

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4Материаллаг байдал .....	14
3.5Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв .....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Албан шаардлага .....	16
4.3 Зөвлөмж .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

## Товчилсонүгийнжагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
НА	Нотлох Ажил
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>61,427,960.45</u></b>	<b><u>54,370,260.55</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	17,853,940.05	15,631,505.15
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	15,653,940.05	13,315,942.66
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,200,000.00	2,315,562.49
3351	Байгууллагаас авах авлага	1,500,000.00	1,615,562.49
3352	Хувь хүмүүсээс авах авлага	700,000.00	700,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	43,574,020.40	38,738,755.40
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	452,700.00	578,300.00
35130	Эм боох материал	452,700.00	578,300.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	21,106,670.40	23,359,670.40
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	22,014,650.00	14,800,785.00
35410	Бичиг хэргийн материал	-	299,600.00
35420	Аж ахуйн материал	3,379,000.00	1,697,500.00
35460	Хүнсний материал	18,635,650.00	12,803,685.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>454,142,085.64</u></b>	<b><u>1,403,155,649.04</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	454,142,085.64	1,403,155,649.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	446,362,085.64	1,395,375,649.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	465,563,830.00	1,457,530,725.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(48,093,841.68)	(87,686,094.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,014,218.00	50,674,218.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,303,587.75)	(39,577,914.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,856,058.00	45,356,058.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		

		(28,514,889.19)	(32,761,641.19)
39217	Ном	1,840,298.26	1,840,298.26
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>7,780,000.00</b>	<b>7,780,000.00</b>
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,780,000.00	7,780,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>515,570,046.09</b>	<b>1,457,525,909.59</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>77,999.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>77,999.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>-</b>	<b>77,999.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	77,999.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>345,165,661.09</b>	<b>1,287,043,525.59</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>345,165,661.09</b>	<b>1,287,043,525.59</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(80,926,303.82)</b>	<b>860,951,560.68</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(80,926,303.82)	(80,926,303.82)
51220	Тайлант үеийн үр дүн	-	941,877,864.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	426,091,964.91	426,091,964.91
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>345,165,661.09</b>	<b>1,287,121,524.59</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>470,482,500.00</b>	<b>1,490,066,638.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>994,940,495.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>-</b>	<b>994,940,495.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	994,940,495.00

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	994,940,495.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>470,482,500.00</b>	<b>495,126,143.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	440,510,700.00	452,926,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	440,510,700.00	452,926,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	737,200.00	13,896,843.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	737,200.00	6,727,623.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,169,220.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	29,234,600.00	28,303,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,234,600.00	28,303,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>477,808,180.34</b>	<b>549,781,773.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>477,808,180.34</b>	<b>549,781,773.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	472,453,901.34	542,612,553.50
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	332,210,175.95	347,298,497.00
210101	Үндсэн цалин	300,280,086.00	262,359,094.00
210102	Нэмэгдэл	-	62,199,942.00
210104	Урамшуулал	31,930,089.95	22,739,461.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,755,169.00	48,042,336.90
210201	Тэтгэврийн даатгал	41,755,169.00	34,141,597.54
210202	Тэтгэмжийн даатгал	-	3,475,184.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,780,147.86
210204	Ажилгүйдлийн даатгал	-	695,036.98
210205	Эрүүл мэндийн даатгал	-	6,950,369.68

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,209,671.00	28,123,300.00
210301	Гэрэл, цахилгаан	2,803,371.00	2,823,300.00
210302	Түлш, халаалт	26,011,300.00	24,900,000.00
210303	Цэвэр, бохир ус	395,000.00	400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,607,600.00	4,082,093.00
210401	Бичиг хэрэг	562,500.00	914,700.00
210402	Тээвэр, шатахуун	908,000.00	812,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	118,100.00	96,270.00
210404	Ном, хэвлэл	-	65,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	66,623.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,000.00	2,126,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	29,279,950.00	45,016,915.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,399,050.00	658,650.00
210502	Хоол, хүнс	26,915,900.00	43,684,065.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	965,000.00	674,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	947,500.00	-
210604	Урсгал засвар	947,500.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	132,400.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	-	132,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,467,400.00	20,038,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,467,400.00	19,462,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	576,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	34,976,435.39	49,878,511.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,552,236.00	3,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,969,800.00	1,762,180.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,454,399.39	48,113,331.60

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,354,279.00	7,169,220.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	7,169,220.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	7,169,220.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,929.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,929.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,334,350.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,334,350.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>(7,325,680.34)</b>	<b>940,284,864.50</b>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>(7,325,680.34)</b>	<b>940,284,864.50</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,404,385.00	426,091,964.91	(79,924,623.48)	516,571,726.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>170,404,385.00</b>	<b>426,091,964.91</b>	<b>(79,924,623.48)</b>	516,571,726.43
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	5,748,319.66	5,748,319.66
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>170,404,385.00</b>	<b>426,091,964.91</b>	<b>(74,176,303.82)</b>	522,320,046.09
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>170,404,385.00</b>	<b>426,091,964.91</b>	<b>(74,176,303.82)</b>	522,320,046.09
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>170,404,385.00</b>	<b>426,091,964.91</b>	<b>(74,176,303.82)</b>	522,320,046.09
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	941,877,864.50	941,877,864.50
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>170,404,385.00</b>	<b>426,091,964.91</b>	<b>867,701,560.68</b>	1,464,197,910.59

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>470,482,500.00</b>	<b>495,126,143.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>470,482,500.00</b>	<b>495,126,143.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	440,510,700.00	452,926,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	440,510,700.00	452,926,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	737,200.00	13,896,843.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	737,200.00	6,727,623.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,169,220.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	29,234,600.00	28,303,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,234,600.00	28,303,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>470,482,500.00</b>	<b>495,126,143.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>470,482,500.00</b>	<b>495,126,143.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>465,128,221.00</b>	<b>487,956,923.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	337,724,850.00	343,254,221.25
210101	Үндсэн цалин	212,045,595.00	197,845,327.09
210102	Нэмэгдэл	101,751,855.00	121,928,478.22
210104	Урамшуулал	23,927,400.00	23,480,415.94
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,284,700.00	49,786,178.75
210201	Тэтгэврийн даатгал	32,783,000.00	35,338,537.75
210202	Тэтгэмжийн даатгал	3,375,400.00	4,058,941.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,700,400.00	2,770,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	675,200.00	692,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал		

		6,750,700.00	6,925,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,214,671.00	28,123,300.00
210301	Гэрэл, цахилгаан	2,803,371.00	2,823,300.00
210302	Түлш, халаалт	26,011,300.00	24,900,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,513,000.00	1,906,423.00
210401	Бичиг хэрэг	143,700.00	125,100.00
210402	Тээвэр, шатахуун	908,000.00	812,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	118,100.00	107,600.00
210404	Ном, хэвлэл	82,100.00	73,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	261,100.00	555,623.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	232,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	45,372,150.00	38,558,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,238,000.00	77,000.00
210502	Хоол, хүнс	41,813,800.00	37,752,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,320,350.00	729,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	180,000.00
210604	Урсгал засвар	-	180,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	132,400.00
210702	Дотоод албан томилолт	-	132,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	200,000.00	19,891,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	19,315,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	576,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,818,850.00	6,124,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	737,200.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,081,650.00	6,124,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,354,279.00</b>	<b>7,169,220.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-

			7,169,220.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	7,169,220.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	19,929.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,929.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	5,334,350.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,334,350.00	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	481229300.00	481229300.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	481229300.00	481229300.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	481229300.00	481229300.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	346291100.00	343254221.25
210101	Үндсэн цалин	210955400.00	197845327.09
210102	Нэмэгдэл	112322400.00	121928478.22
210104	Урамшуулал	23013300.00	23480415.94
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46749300.00	49786178.75
210201	Тэтгэврийн даатгал	32897400.00	35338537.75
210202	Тэтгэмжийн даатгал	3463000.00	4058941.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2770500.00	2770200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	692500.00	692700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6925900.00	6925800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	28123300.00	28123300.00
210301	Гэрэл, цахилгаан	2823300.00	2823300.00
210302	Түлш, халаалт	24900000.00	24900000.00
210303	Цэвэр, бохир ус	400000.00	400000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1350800.00	1350800.00
210401	Бичиг хэрэг	127700.00	125100.00
210402	Тээвэр, шатахуун	812400.00	812400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	105,000.00	107,600.00

210404	Ном, хэвлэл	73,000.00	73,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	232,700.00	232,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>38,558,100.00</b>	<b>38,558,100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,000.00	77,000.00
210502	Хоол, хүнс	37,752,100.00	37,752,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	729,000.00	729,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>180,000.00</b>	<b>180,000.00</b>
210604	Урсгал засвар	180,000.00	180,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>132,400.00</b>	<b>132,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	132,400.00	132,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,719,600.00</b>	<b>13,719,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,143,600.00	13,143,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,124,700.00</b>	<b>6,124,700.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,124,700.00	6,124,700.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>481,229,300.00</b>	<b>481,229,300.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>452,926,000.00</b>	<b>452,926,000.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	452,926,000.00	452,926,000.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>28,303,300.00</b>	<b>28,303,300.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	28,303,300.00	28,303,300.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>29.00</b>	<b>31.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>-</b>	<b>-</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>29.00</b>	<b>31.00</b>

650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	18.00	19.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	11.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>737,200.00</b>	<b>13,896,843.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>737,200.00</b>	<b>13,896,843.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	737,200.00	6,727,623.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	555,623.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	555,623.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	6,172,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	6,172,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	737,200.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	737,200.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	7,169,220.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	7,169,220.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	7,169,220.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	737,200.00	13,896,843.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	737,200.00	13,896,843.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	737,200.00	6,727,623.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,169,220.00

### 3.Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана гэж заасны дагуу Цэцэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага болон шилэн данстай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Эл би альфа экспэйншин аудит ХХК-ны аудитор Г.Баясгалан 2022 оны 02 дүгээр сарын 20-нээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зорилго: Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэг нь хүүхэд бүр бүтээлч үйлээрээ хагжих орчин бүрдүүлж, өдөр тутмын сургалт, хөгжүүлэх үйл ажиллагааны чанарыг тасралтгүй дээшлүүлж бие сэтгэлээр эрүүл ,өөртөө итгэлтэй , эерэг мэдрэмж , хандлагатай ЗӨВ зан үйлтэй хүүхдийн хөгжлийг хангана.

Зорилт: Монгол хэл бичиг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багш ажилчдын оролцоог нэмэгдүүлэн ажиллах. Цэцэрлэг нь үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээг хамтын оролцоотой хийж, үр дүнд суурилан менежмент үйл ажиллагааг сайжруулах. "Чадварлаг багш" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих, тэдний мэдээлэл харилцаа холбооны технологийн ур чадварыг хөгжүүлэх хамрах тойргийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, 5 настай хүүхдийг СӨБ-д 100 хамруулна. Үүнд:

- *Сургалтын үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, үр дүнг тооцох*
- *Хүүхдийн хөгжлийн түвшиндгара буй ахиц өөрчлөлтийг үнэлэн хөгжлийн тэмдэглэл хөтлөн үйл ажиллагаандаа судалгаа дүгнэлттэй ажиллах*
- *Хүүхэд хөгжүүлэх ажлыг сургалтын ажилтай холбон төлөвлөж, түүний явц үр дүнд чиглэгдсэн ажлуудыг зохион байгуулах хяналт тавих*
- *Багш, туслах багш нарын ур чадварыг сайжруулах, техник хэрэгслийг ашиглах чадварыг нэмэгдүүлэх*
- *Хүүхэд бүрийг эцэг эхчүүд гэр бүлийн орчинд хэрхэн хөгжүүлэх төдөвшүүлэхэд сурган хүмүүжүүлэх чиглэлээр туслах, олон нийт, иргэд рүү хандсан сургалт үйл ажиллагааг зохион байгуулах*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоо Боловсрол шинжлэх ухааны яамнаас шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүйгэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 481.2 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 4.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,457.5 сая төгрөгөөр буюу 2.82 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, хөшөөтийн багийн цэцэрлэгийн барилгыг орлогод авснаар үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэн байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 38.7 сая төгрөг болж 4.8 сая мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 44.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр Боловсролын газраас 0.0736 сая төгрөгийн ариутгалын бодис, 1.5 сая төгрөгийн бэлэн бүтээгдхүүн ирсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 566.6 сая төгрөг байсан бол оны эцэст 1,563.7 төгрөг болж 997.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цэцэрлэгийн барилгыг орлогод авсантай холбоотой байна .

Тайлант онд үндсэн хөрөнгийг акталж устгаагүй байна.

Тайлант онд оны эхэнд өр төлбөргүй байсан бөгөөд оны эцэст нийгмийн даатгалын тайлангийн кодын зөрүүтэй холбоотойгоор 0.078 сая төгрөгийн өр төлбөртэй болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 515.5 сая төгрөг байсан оны эцэст 1,457.5 сая төгрөг тайлант онд 941.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант үеийн үр дүн 941.9 мянган төгрөгийн ашигтай байгаа нь цэцэрлэгийн барилга шинээр баригдсантай холбоотой.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Цэцэг сумын цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 481.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 481.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Боловсрол Шинжлэх Ухааны яамнаас тус байгууллагын төсвийг 481.2 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 481.2 сая төгрөгийн төсөв баталснаас 452.9 сая төгрөгийг боловсролын яамнаас, 28.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 339.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3,1 сая төгрөг нийт 339.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 324.6 сая төгрөгийг зарцуулж 15.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 481.2 сая төгрөг буюу 100 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа хангамж, бараа материалын зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, үндсэн үйл ажиллагааны зардлыг төлөвлөгөөний дагуу зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулсан байна.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар Боловсролын Шинжлэх Ухааны Яамнаас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны дэмжлэг хоёр хүнтэй холбоотой 7.2 сая төгрөг, орон

нутгийн хөгжийн сангаас 6.0 сая төгрөг халаалтын засварт, ариутгалын зардалд 0.72 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс 98 хугацаандаа оруулсан 52 хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 3 мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,173,750 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг 11.33%, 1 зөвлөмжийг бүрэн, 1 албан шаардлагыг 70% хэрэгжүүлсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар авлага, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 2 зөвлөмж өгсөн болно.

### **4.1 Залруулсан алдаа**

Залруулсан алдаа байхгүй.

### **4.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөгдөөгүй байна

### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 4.3.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх оны авлагыг бүрэн барагдуулаагүй, авлага бууруулах талаар арга хэмжээ авч бүрэн барагдуулж ажиллах.

Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална", НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах.

#### 4.3.2 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Илрүүлэлт: Шилэн дансны хуульд заасан сар, улирал бүрийн төсвийн гүйцэтгэлийн нийт 52 мэдээг цаг тухай бүрт нь мэдээллээгүй, төсвийн гүйцэтгэлийн мэдээллүүдийг хуулийн дагуу заасан хугацаанд тогтмол мэдээллэх.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, 6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор, 6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, 6.1.5.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор, 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цэцэг сумын цэцэрлэг	0	0	0	0	0	0	0	0	2	15631505.15

### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

АХЛАХ АУДИТОР:

Г. БАЯСГАЛАН